



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2012 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 145

Улаанбаатар хот

“Азиа пасифик секьюритис” ХХК-ийн  
тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, 14, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 8.2.8 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Азиа пасифик секьюритис” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.
2. “Азиа пасифик секьюритис” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.
3. Тусгай зөвшөөрөл хүчингүй болсонтой холбогдуулан тус компанийн харилцагчдыг брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй бусад компанид шилжүүлэх ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлж ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

001534